

НИЙТИЙН САЙН САЙХНЫ ТӨРИЙН ХЭВ МАЯГУУД

Г.Түмэннаст
Социологийн ухааны магистр

Харьцуулсан нийгмийн хамгаалал

Нийтийн сайн сайхны төрийн харьцуулсан судалгаа нь дэлхийн II дайны дараачаас хөгжиж ирсэн гэж хэлж болно. Учир нь дайны дараах хорь гаруй жилийн туршид барууны ертөнцөд нийгмийн хамгааллын системийн их өсөн тэлэлт тохиосон юм. Судлаачид энэ үеийг нийтийн сайн сайхны төрийн хөгжлийн алтан үе хэмээн нэрийддэг. Нийгмийн хамгааллын харьцуулсан шинжилгээ нь шинжлэх ухааны онол аргазүйн сургуулийн (школын) хувьд үндсэндээ дөрвөн чиглэлд явагдаж байгаа талаар Шмидт тэмдэглэсэн байна. Түүний үзсэнээр нийгмийн хамгааллын бодлогын нийгэм, эдийн засгийн хүчин зүйл болон үр нөлөө, үр дагаварыг тодорхойлох нийгэм эдийн засгийн шинжилгээний сургууль (гол төлөөлөгч нь Виленски (Wilensky)), нэг талаас орчин үеийн ардчилсан дэглэмийн үе дэх хөдөлмөр болон баялгийн хоорондох зөрчил, нөгөө талаас нийгмийн хамгаалалт төрийн зөрчилт талуудыг тодорхойлох неомарксист төрийн онолын сургууль (гол төлөөлөгч нь Стефенс (Stephens), Оффе (Offe) нар), уламжлалт нийгмийг (гэр бүл, хамаатан садны) халж буй болон орчин үеийн нийгмийн аж үйлдвэржилт, эдүүгээжилтийн сөрөг үр дагаваруудыг хөнгөвчлөх үүднээс нийгмийн хамгааллын институцийн өсөн томролт, чиг үүргийн өөрчлөлтийг тодорхойлох макросоциологийн сургууль (гол төлөөлөгч нь Албер (Alber), Флора (Flora)), улс төрийн хүчин зүйл бүхий нийгэм, эдийн засгийн нөлөөлөл, шахалт хэрхэн төрөн гарч буй талаар, түүнчлэн нийгмийн бодлогын түвшин, хөгжлийн олон улсын түвшин дэх ялгааг тодорхойлох улс төрийн институциональ сургууль (гол төлөөлөгч нь Шмит (Schmit), Андерсен (Andersen), Хиггинс (Higgins)) зэрэг болно. (Schmidt, 1988, p. 144) Нийгмийн хамгааллын харьцуулсан судалгааны аргазүйн ерөнхий тавил нь судалгаанд сонгон авсан хувьсах хэмжигдэхүүн болон судлагдан буй кейсийн хэмжээнээс хамаарах ба дөрвөн үндсэн чиглэлийг бүтээдэг болохыг доорх хүснэгтээс харж болно.

Хүснэгт 4. Нийгмийн хамгааллын харьцуулсан судалгааны аргазүйн ялгаа

	Судлан буй тохиолдлын тоо		
		Бага	Их
Хувьсах хэмжигдэхүүний тоо	Бага	Кейс судалгаа (a)	Олон улсын харьцуулалт (b)
	Их	Макро-түүхэн харьцуулалт (c)	Макро (олон түмний хэмжээний) статистик харьцуулалт (d)

(Schmid, 1996, p. 30)

Кауфманн “Нийтийн сайн сайхны төрийн хувилбарууд” бүтээлдээ улс орнуудын төрийг тодорхой хэв маягчлалд оруулаагүй болов ч, харьцуулсан нийгмийн хамгаалалд төр ба нийгмийн харилцаа, эдийн засаг ба баялгийн хуваарилалтын дэглэм, нийгмийн бодлогын түлхүүр институц, чиглэл гэх зэрэг шалгууруудаар дэлхийн томоохон нийтийн сайн сайхны төр улсууд болох Герман, Америк, Англи, Шведийн төр, засгийн газрын бодлого, тогтолцоог түүхэн харьцуулалтын аргаар авч үзсэн нь аргазүйн ихээхэн ач холбогдолтой юм. (Kaufmann F. X., 2003, pp. 17-19) Орчин үеийн харьцуулсан нийгмийн хамгаалал судлалд, төдийгүй ерөөс нийгмийн хамгааллын судалгаанд аргазүйн ач холбогдол бүхий зарим нэг тулгуур ойлголтуудыг судлаач Шмидт дэвшүүлсэн байдаг. Эдгээр нь бүхэл улс орныг гол болгох улс төрийн байгууламж буюу полити (polity), улс төрийн бодлого, харилцааг илэрхийлэх политике (politics), нийгэмд буй болсон тодорхой асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн бодлого болох полиси (policy) зэрэг болно. (Schmid, 1996, pp. 70-71)

Британий профессор нийтийн сайн сайхны төрийн бодлогыг хамгаалан дэмжигч Титтмусс “Нийгмийн бодлого гэж юу вэ?” гэсэн өгүүлэлдээ барууны капитлист орнуудын нийгмийн хамгааллын системийн хэв маягуудыг анх удаа дэвшүүлсэн бөгөөд харьцуулсан нийгмийн хамгааллыг үндэслэсэн байна. Тэрээр аж үйлдвэрийн ололт, ризидуаль болон нийтийн институцийн гэсэн гурван хэв маягт хуваасан байна. (Richard Tittmus, 1974) Андерсен нийгмийн хамгааллын системийн ялгаатай хэв маягуудын талаар “Халамжит капитализмын гурван ертөнц” алдарт бүтээлдээ хөндөн тавьж, товчхондоо нийгмийн хамгааллын харьцуулсан судалгааны галыг үлэмж ихээр өрдсөн байна. Тэрээр гурван үндсэн шалгуурын хүрээнд шинжилгээ хийсэн бөгөөд *эхнийх нь*

нийгмийн хамгааллын тогтолцооны хүрээнд төр, зах зээл, гэр бүлийн үүрэг хариуцлагаа хэрхэн хуваарилсан байдал, *удаах нь* төрөөс хүн амын социаль амьдралыг зах зээлээс үл хамаарсан байдлаар бүрдүүлэх буюу ажиллах хүчин бараа, таваар мэт арилжигдах шинжийг хязгаарлах бодлого²⁴⁸ (decommodification) ямар түвшинд байгаа, өөрөөр хэлбэл хөдөлмөрийн зах зээлийн орлого болон нийгмийн хамгааллыг хүчтэй тусгаарлах зарчмыг, *сүүлийнх нь* нийгмийн бодлого буюу төрийн интервенцээр дамжуулан нийгмийн социаль бүтэцэд үзүүлж буй нөлөөлөл, өөрөөр хэлбэл нийгмийн тэгш бус байдлыг багасгах, эв нэгдлийг бүтээх зорилго бүхий арга хэмжээ, үйлчилгээ ямар түвшинд байгаа зэргийг судлан барууны капиталист орнуудын нийгмийн хамгааллын гурван хэв маягийг дэвшүүлжээ. (Esping-Andersen, 1990) Э.Андерсений нийгмийн хамгаалалт төрийн хэв маягчлал анхдагч бөгөөд шинэлэг байсан хэдий ч, судлаачдын зүгээс зарим шүүмжлэлтэй тулгарах болсон байна. Түүний бүтээл хэдийгээр капиталист хөгжингүй ертөнцийн нийгмийн хамгаалалд төвлөрсөн болов ч, юуны өмнө уламжлалт социаль бүтэцтэй, нийгмийн амьдралд гэр бүлийн учир холбогдол, нөлөө ихтэй европын өмнө зүгийн орнууд болох Испани, Португал, Грек, цаашилбал зарим талаар Итали зэрэг (nachholende Wohlfahrtstaat) хэмээгддэг улс орнууд энэхүү хэв маягчлалын гадна үлдсэн, мөнхүү дээр хэв маягчлалд хамрагдаагүй хуучин социалист дэглэмд байсан, төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж буй төв болон зүүн европын орнуудын асуудал гарч ирсэн (Польш, Унгар, Чух гэх мэт) гэх мэтийг дурдах хэрэгтэй. (Naegel, 2008, pp. 51-52)

Түүнчлэн институцийн онолын үүднээс ихээхэн шүүмжлэгдэх бөгөөд уг үзэл ёсоор улс орнуудын нийгмийн бодлогын хөгжил нь өөрийн гэсэн өвөрмөц бөгөөд түүхэн замналтай агаад үүнээс хамаарах зарчим нь (pathdependent) улс төрийн ялгаатай үр дүнгүүдийг бүтээж ирсэн хэмээдэг. Тиймээс дээрх гурван хэв маягт орох улс орнууд ч тус бүрдээ өөр замналтай, төлөвшилтэй гэдэг. Зарим талаар Андерсений судалгааг нийгмийн хамгааллын институцүүдийн чиг үүрэг, үр нөлөөг үнэлэхдээ зарим нэг хэсгийг л тоон судалгаандаа хамруулж, нийгмийн халамжийн чухал арга хэмжээнүүдийг (категорчилсон болон халамжийн мөнгөн тэтгэмжүүдийг) орхигдуулсан гэх нь ч бий. Нийгмийн хамгааллын хөгжлийн загваруудын талаар хөндөхийн тулд уг салбарын түүхэн хөгжилд онцгой байр эзэлсэн хоёр загварыг ярих хэрэгтэй болно. Бисмаркийн болон Бэвэрижийн загвар гэсэн ойлголт нийгмийн хамгаалалд бий болж, өөр өөрийн онцлог бүхий тогтолцоог буй болгосон билээ. Тодруулбал Германы төрийн зүтгэлтэн Отто Бисмаркийн бий болгосон төрийн нийгмийн даатгалын тогтолцоо, нөгөөх нь Британий улс төрч, лорд Влиям Бэвэрижийн нийтийн сайн сайхны төрийн загвар юм. Бисмаркийн загвар нь XIX зууны сүүлээр Пруссийн Аерманд бий болж, хэдхэн арван жилийн дотор европ цаашилбал дэлхий даяар тархсан шимтгэл төлөлт дээр суурилсан төрийн даатгалын тогтолцоо бол, дэлхийн II дайны дараа Британий засгийн газраас дэвшүүлсэн Бэвэриж төлөвлөгөө нь төлбөрийн чадвараас үл хамааран хүн амын суурь баталгааг хангахад чиглэсэн төсөвт суурилсан тогтолцоо билээ. Энэхүү хоёр түүхэн загвар нь нийгмийн хамгааллын харьцуулсан судалгааны талбарыг үлэмж баяжуулсан юм. Андерсеноос хойш нийгмийн хамгааллын хэв маягчлалыг дэвшүүлсэн судлаачид цөөнгүй төрөн гарсан юм. Тэдгээрээс заримыг нь дурдвал Феррера (Ferrare 1996) *англо-саксоны, бисмаркийн, скандинавын болон өмнөдийн*, Боноли (Bonoli 1997) *Британий, эх газрын, умардын болон өмнөдийн*, Корпи болон Палме (Korpi and Palme, 1998)

248 Нийгмийн хамгааллын судалгаанд Андерсений танил болгосон энэхүү ойлголт нь (Decommodification) Марксын бүтээлүүдэд хүнийсэх (die Entfremdung) гэсэн агуулгыг илэрхийлэхэд чиглэсэн бараа тавааржих (die Kommodifizierung) гэсэн ойлголтоос угшилтай бөгөөд эдийн засгийн түүхч Полани институцийн судалгаандаа гүнзгийрүүлэн шинжилжээ.

нар суурь хамгааллын, корпоративист, бүрэн хамралтын, зорилтот, сайн дурын төрийн хангамжийн гэсэн хэв маягуудад хуваасан байна. (Arcanjo, 2006)

Умардын буюу нийтийн институцийн загвар

Умардын загварын онцлог шинжүүд нь нэгдүгээрт, нийгмийн хамгааллын тэтгэмжүүд нь үндсэндээ төрийн сектороор дамжин хүрэх бөгөөд хувийн хэвшил, филантропи, сайн дурынхан, гэр бүлд өчүүхэн орон зай л үлдэнэ. Хоёрдугаарт, дээрх тэтгэмжүүд нь олон талт бөгөөд универсал, дахин хуваарилахад баримжаалсан, харьцангуй өндөр түвшинд тэгш байдлыг бүтээдэг. Универсал үйлчилгээ нь ахмад настны тэтгэвэр, эрүүл мэндийн тусламж, хүүхдийн халамж, боловсрол, хүүхдийн тэтгэмж, эрүүл мэндийн даатгал зэрэг нь зорилтот бүлэгт бус, харин төлбөрийн чадвар харгалзахгүй бүх хүн амд чиглэдэг гэсэн утгатай. Гуравдугаарт, нийгмийн хамгааллын арга хэмжээнүүд нь хөдөлмөр эрхлэлтэд хамаарах даатгалын шимтгэлээр гэхээсээ илүүтэй үндсэндээ татварын орлогоор санхүүждэг ба 1980-аад оны үед Дани, Норвег, Швед зэрэг оронд татварын орлого ДНБ-ий 50 илүү хувийг бүрдүүлж байжээ. Дөрөвдүгээрт, умардын нийтийн сайн сайхны төр нь Америк, Енаад, Австрали зэрэг орнуудын адилаар нийгэмд аз дутсан иргэдийн аюулгүй байдлыг хангах сүлжээ (safety net) мэтээр хэзээ ч ойлгогдож байгаагүй. Харин дайны дараачаас нийгмийн хамгааллыг эдийн засгийн бодлогын интеграл хэсэг агаад эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажилгүйдлийг багасгах, амьдралын стандартыг нэмэгдүүлэх үүрэгтэй гэж үзэж байсан. (Hilson, 2008, p. 90)

Улс төрийн эдийн засгийн онцлог нь социаль демократизм болон этатизмд тулгуурлах бөгөөд социаль демократ загвар нь ангийн идэвхижүүлэлт бол тэгш байдал, шударга ёс, эрх чөлөө, эв нэгдлийн талаарх социалист үзэл санааг хэрэгжүүлэх арга хэрэгсэл бөгөөд үүнийг парламентын ардчиллаар дамжуулан гүйцэлдүүлэх боломжтой хэмээн үздэгээрээ онцлог болно. (Esping-Andersen, 1990) Швед, Дани, Финлянд, Норвеги зэрэг орнуудаар умардын загварыг төлөөлүүлэн бичих нь нийтлэг. Институцийн гол үнэт зүйлс, зорилго нь нийгмийн тэгш байдал, хүн амын баталгаат байдал, зах зээлийн ширвэлтээс хамгаалан, уг хатуу ширүүн харилцааг зөөллөх зэрэг болдог. Нийгмийн хамгааллын бодлого нь улс орныг бүхэлд нь анхааралдаа байлгахад чиглэдэг ба түгээмэл үйлчилгээг бий болгодог учраас эдгээр орнууд нь нийгмийн хамгааллын универсализмын (welfare universalism) жишээ болон яригдах нь бий. Титмуссын үзсэнээр нийтийн институцийн загварын үед нийгмийн хамгаалал нь нийгэм дэх интеграцчиллын үүргийг үлэмж хэмжээнд хэрэгжүүлдэг институц болдог. Хүн амын суурь хэрэгцээгээ хангах зах зээлийн зарчмаас гадуур төрөөс түгээмэл шинжтэй үйлчилгээг буй болгодог. Нийгмийн баялгийг байнга дахин хуваарилах нь нийгмийн тэгш байдлын зарчмын нэг хэсэг болдог. (Richard Tittmus, 1974, p. 29)

Нийгмийн баялгийг дахин хуваарилах түвшин хамгийн өндөртэй орнууд эл загварт багтах бөгөөд түүний онцлог нь дээрээс доош чиглэсэн, чинээлэг хэсгээс ядуу хэсэгт хуваарилах байдлаар илэрдэг. Мэдээж энэхүү хуваарилалт нь дан ганц мөнгөн шилжүүлэг биш бөгөөд хүн амыг хамарсан бүх нийтийн нийгмийн үйлчилгээгээр илүүтэй явагддагаараа онцлог юм. Судлаачид скандинавын орнуудад нийгмийн хамгааллын хүрээнд үйлчилгээг илүүтэй цоглоодог байхад, эх газрын европт мөнгөн шилжүүлгээр хуваарилахыг илүүд үздэг гэжээ. (Kaufmann, 2000) Мэдээж энэ загвар нь дотооддоо зөрчлийг бий болгодог ба үүнийг санхүүгийн хямралт байдал ба баялгийн дайжилт зэрэгтэй холбон үзэх нь бий. (Ulrich, 2005) Хөдөлмөрийн идэвхитэй бодлогыг гол болгодог тул бүрэн ажил эрхлэлтийг бий болгох зорилт тавигдана. Хүйсийн хувьд эрэгтэй болон эмэгтэйчүүдийг хөдөлмөрийн харилцаанд тэгш эрхтэйгээр оролцуулах явдлыг төрөөс бодлогоор дэмждэг. Тиймээс хөдөлмөрийн зах зээлийн дэг ёс нь төрийн ихээхэн оролцоотойгоор тогтох ба тэнд уг зах зээлийн бүрэн уян хатан байдал төдийлөн хангагдаж чадахгүй, харин хяналтын доор уян хатан байдал л тогтоно. Нийгмийн хамгааллын салбарт болон зардалд хувийн хэвшлийн оролцоо хийгээд хувь хэмжээ бага байдаг.

Скандинавын хойгийн орнууд зүүний чиглэлийн буюу социаль демократ улс төрийн намуудын удаан хугацааны улс төрийн нөлөөлөл доор байсан ба социалист үзэл санаа, ажилчин ангийн

дайчилгааны хүчтэй уламжлал бий болсон юм. Энэ нь хөдөлмөрийн болон гэр бүлийн хүрээнд явуулах нийгмийн бодлогын онцлогоос нь илэрхий харагдана. Хөдөлмөр эрхлэлтийн идэвхитэй бодлого нь хүмүүсийг хөдөлмөрийн зах зээлд интеграцчилах өргөн хэмжээний хөтөлбөрүүдийг багтаах ба хөдөлмөрийн зах зээлд хүйсийн тэгш оролцоог эрхэмлэх болдог. Нөгөөтэйгүүр бүрэн ажил эрхлэлтийн бодлогыг илэрхийлэхийн дээр умардын загварын ерөнхий үзэл баимтлал нь ажилгүйдлийн түвшин гурваас ихгүй хувьтай байгаа үед уг бодлого хэрэгжиж байна гэж үздэг. Умардын орнуудад эх газрын европыг бодвол хүүхдийн цэцэрлэг, ясли, өдөр өнжүүлэх төвүүдийг төрөөс анхаарч, хүүхдийн халамжийн дэд бүтцийг илүү сайн хөгжүүлсэн нь эргээд хөдөлмөрийн харилцаанд хүйсийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн оролцооны түвшинг дээшлүүлэхэд чиглэдэг. Нөгөө талаас аж үйлдвэрийн хувьсгалын нөлөөгөөр европт нийтлэгээр тогтсон эрэгтэйчүүд өрхөө тэжээгч (bread winner) харин эмэгтэйчүүд (house keeper) ар гэрээ авч явагч гэр бүлийн уламжлалт загвар энэ улс орнуудад социалист хөдөлмөрийн бодлогын нөлөөгөөр эвдэгдсэн гэж үздэг.

Англи Саксоны буюу ризидуал загвар

Улс төрийн эдийн засгийн хувьд либерализм, зүүний либерализм, түүнчлэн лайсец фэйрийн²⁴⁹ (laissez faire) үзэлд суурилдаг. Судлаачдын дунд АНУ, Шинэ Зеланд, Австрали, Канад болон Их Британи, цаашилбал Нидерланд зэрэг орнуудыг эл хэв маягийн жишээ болгон бичих нь бий. Хувь хүний эрх чөлөө, зах зээлийн чадавхи, хувь хүний хариуцлага бол уг загварын гол үнэт зүйл, эрхэмлэх зорилго болдог байна. Хөдөлмөрийн зах зээлийн өсөлтийг эрхэмлэх бөгөөд түүнийг уян хатан байлгах, төрийн оролцоог бага байлгах нь чухалчлагдана. Хөдөлмөрийн идэвхитэй болон идэвхигүй бодлогын арга хэмжээний аль нь ч төрөөс институцчилсэн байдал доогуур байдаг. Нийгмийн хамгааллын салбарын гол түшиц талбар нь зах зээл юм.

Титмуссын үзсэнээр нийгмийн хамгааллын ризидуаль загварт хүмүүсийн хэрэгцээг хангах жам ёсны (нийгмээс өгөгдсөн) хоёр суваг байх ба эдгээр нь зах зээл болон гэр бүл болно. Зөвхөн эдгээр институцүүд хэрэгцээг хангаж чадахгүй байгаа тохиолдолд сая нийгмийн хамгааллын институцүүд үүрэг гүйцэтгэхээр гарч ирэх ба гэхдээ зөвхөн тодорхой цаг хугацаанд л боломжтой. Профессор Пийкокийн хэлсэнчлэн энэ тохиолдолд нийтийн сайн сайхны төрийн үнэн зорилго нь хүмүүсийг түүнгүйгээр хэрхэн аж төрөхөд суралцуулах явдал болно. (Richard Tittmus, 1974, p. 31) Нийгмийн хамгааллын үйлчилгээний хувьд сонгон хамруулах (selective approach) хандлага зонхилох ба халамжийн үйлчилгээ уг салбарын түлхүүр бодлогын арга хэмжээ, институц нь болдог. (Ulrich, 2005, p. 52) Тиймээс орлого тодорхойлох (means testing) замаар хэрэгжүүлэх нийгмийн хамгааллын арга хэмжээнүүд зонхилно.

Англо саксоны орнуудын хувьд ядуурлын хуулийн (poor law) тогтолцоо бол гол уламжлал бөгөөд XVI зууны босгонд батлагдан хэрэгжих болсон Элизабетийн хуулийн цаашдын хөгжил, өв уламжлал нь Британи, цаашилбал Америк болон бусад англи хэлтний орнуудад нийгмийн хамгааллын өвөрмөц онцлог бүхий системийг бүтээжээ. Халамжийн үйлчилгээнд сонгон хамруулах зарчим, орлого тодорхойлох арга хэмжээ нь ядуу хэсэгт ихээхэн хэмжээний хаяг шошго наах үр дагаварыг бий болгодог. Энэ загварын үед нийгмийн системд буй болох социаль зөрчлүүд нь нийгмийн задрал (disintegration), нийгмээс хаягдахуй (exclusion), аюултай хийгээд доод анги (dangerous and underclass) зэрэг асуудлууд болно. Зарим шүүмжлэлт судлаачид Америкт хүмүүст гурван шүүлтүүр даван доош гоожсон бол сая халамж өгөхөөр институц бүрэлдсэн ба эхнийх нь, зах зээлийн гадна хаягдсан бол, удаах нь гэр бүлээс, харин эцэст нь сүм юм уу, шоронд илгээгдээгүй бол сая төрийн халамжийн үйлчилгээ хүртээмжтэй гэсэн нь бий. Тиймээс шорон бол нэг талаас гэмтнийг тусгаарлан шийтгэх, нөгөө талаас тэднийг мэнд оршин тогтнох (survival) халамжийн үүрэг гүйцэтгэдэг байна. Тэнд хүний эрхийн зохих стандарт нь хоол, хувцас, дулаан орон байр гэсэн наад захын хэрэгцээг хангадаг билээ. Америкийн нэг онцлог бол ядуусын талаар явуулах төрийн зохицуулалт болон менежмент нь нийгмийн хамгаалал гэхээсээ өөр утгад шилжих тал бий. Учир нь

249 Францад бий болсон ойлголт бөгөөд хувийн хэвшлийн үйл хэрэгт төр бүү оролц, зөнгөөр нь орхи гэсэн утгатай хэллэг юм.

Америкийн систем бол ядуу эрчүүдийн хувьд нийтийн сайн сайхны төр гэхээсээ эрүүгийн бодлогын төр (criminal justice state) гэх үндэс бий. Учир нь бусад хөгжилтэй орнуудаас шоронгийн индекс хамгийн өндөртэй бөгөөд зарим утгаар шорон ядуу эрчүүдийн хувьд эрүүл мэндийн болон боловсролын босго стандартыг хүртэх талбар болдог аж. (Allan Cochrane, 2001, p. 147)

Нийгэм дэх баялгийг хуваарилахад зах зээл үнэмлэхүй хийгээд ноёлох институци болдог тул нийгмийн баялгийн дахин хуваарилалтын түвшин бага байна. Өөрөөр хэлбэл зах зээлийн дараах орлого хүн амын амьжиргаанд төдийлөн нөлөө үзүүлж чадахгүй. Нийгмийн халамжийн зах зээлжсэн байдал бусад загвараас хавьгүй өндөр бөгөөд даатгал болон бусад хамгааллын (тухайлбал асрамжийн) зардалд хувийн хэвшлийн хувь хэмжээ өндөр байдаг. Тухайлбал ахмад настны болон эрүүл мэндийн үйлчилгээнд хувийн хэвшлийн гүйцэтгэх үүрэг ихээхэн буй. Хакер (Hacker) америкийн нийгмийн бодлогын хөгжлийг судлан ажил олгогчид суурилсан эрүүл мэндийн тусламж болон тэтгэврийн үйлчилгээний нэгэн зууны хөгжлийг судлан төрийн болон хувийн системийн ялгаатай замналыг тодорхойлсон. Нийгмийн бодлогын эл хоёр арга хэмжээ нь холимог тогтолцоотой боловч ялгаатай замаар хөгжиж ирсэн байна. Эрүүл мэндийн үйлчилгээний хувьд хувийн үйлчилгээ тэргүүлэх үүрэг гүйцэтгэж, харин төрийн үйлчилгээ хоёрдогч, түүнийг нөхөн гүйцээгч байдлаар, харин тэтгэврийн хувьд төрийн үйлчилгээ тэргүүлэх, хувийн үйлчилгээ хоёрдогч, нөхөх байр сууриар хөгжсөнийг илрүүлсэн байдаг. Түүнийхээр эдгээр нь тус бүрдээ улс төрийн ашиг сонирхлын өвөрмөц орчныг бүтээж ирсэн ба хуваарилалтын ялгаатай үр нөлөөг бий болгосон байна. (Pierson, 2002) Мэдээж Англо саксоны загварт багтах аль нэг орны нийгмийн хамгааллын бүхий л салбарт хувийн хэвшил ноёрхсон гэж үзэж болохгүй боловч, бусад хэв маягуудыг бодвол зарим салбарт хувийн хэвшлийн оролцоо зонхилдгыг үзэж болно.

Төрөөс гадуурх тусламжийн хөдөлгөөний уламжлал ихээхэн хөгжсөн ба энэ нь одоо ч хадгалагдсаар байгаа. Иргэний нийгмийн зүгээс тусламжийн болон буяны хөдөлгөөнүүд анх Англид XIX зууны эхний хагасаас үүсч, XX зууны эхний хагас хүртэл хүчтэй өрнөсөн бөгөөд нийгмийн хамгааллын асуудлыг хариуцдаг томохон тогтолцоо болон төлөвшжээ. Өдгөө сүм хийдүүд, буяны байгууллагууд, хүмүүнлэгийн сангууд нийгмийн хамгааллын энэ хэв загварт бусдаасаа хүчирхэг үйлчилгээ үзүүлнэ. Төрийн халамжлан тэтгэх үзэл санаа ба сэтгэлгээ нийгмийн нэгж хэсэгт ч ихээхэн сул байх ба энэ нь англи саксоны орнууд дотроос Америкт илүү хүчтэй илэрдэг. Төрийн халамж бол хамааралт байдлыг бүтээдэг гэх үзэл төлөвшсөн байдаг учраас элитүүд төдийгүй бусад ангиудын хувьд ч нийтийн сайн сайхны төр хэмээх ойлголтод итгэлтэй бус ханддаг. (Kaufmann F.-X.

, 2000) Америкт төрийн нийгмийн хамгааллын тогтолцоо нэгдсэн үндэстний хэмжээнд дэлхийн II дайны өмнө сая нэг бий болсон билээ. Өмнө нь дайны XIX зууны II хагасаас иргэний дайнд оролцогчид, бэлэвсэн эмэгтэйчүүд, өнчин хүүхдүүдэд зориулсан тэтгэмжүүдийг умардын штаатууд, XX зууны босгонд буюу 1902 онд Мэрилендад 1920 он гэхэд 43 штаатад эрүүл мэнд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан заавал даатгах даатгалын тогтолцоо нэвтэрсэн байна. Мөн 1921 онд сонгох эрхээ авахын өмнөхөн эмэгтэйчүүдийн бүлэг эх нялхсын эрүүл ахуй болон дэмжлэгийн хуулийг батлуулсан байна. Гэвч 1935 онд “Нийгмийн хамгааллын хууль” гарснаар сая л нэг нэгдсэн үндэстэн болон штаатын хоорондын харилцаанд нийгмийн хамгааллын систем de facto утгаар бий болсон юм. (Kaufmann F. X., 2003)

Нөгөө талаас тус орны хувьд нийгмийн зонхийг тусгаар жижиг өмчтөнүүд бүрдүүлж ирсэн онцлогтой нь ихээхэн холбоотой. Тухайлбал Америк ажилчин ангийн хөдөлгөөн, түүний эвлэлдэн нэгдэх түүхэн туршлага гэхээсээ илүүтэй арьсны болон боолчлолын эсрэг хөдөлгөөний уламжлалтай орон юм. Тиймээс эл оронд үйлдвэрчний эвлэлийн хөгжил сул, басхүү нийгмийн хамгаалалд гүйцэтгэх үүрэг нь эх газрын европын орнуудыг бодвол бараг үгүй юм. Тухайлбал Ротштейн (Rothstein) үйлдвэрчний эвлэл нийгмийн хамгаалалд нь ихээхэн байр суурь, үүрэгтэй байдаг орнуудыг бодвол Америкт нийгмийн хамгааллын улс төр нь үйлдвэрчний эвлэлээс гадуур төлөвшсөн буюу түүний нөлөө харьцуулшгүй бага байгааг хэлсэн байдаг. Тэрээр ажилгүйдлийн даатгалын бодлогод үйлдвэрчний эвлэлийн үүргийг харьцуулан судалсан байх ба ажилгүйдлийн даатгалын үйлдвэрчний эвлэл хариуцдаг гент (Ghent) системийг хэрэгжүүлсэн орнууд дахь үйлдвэрчний гишүүдийн эвлэлдэн нэгдэх явдал бусад орнуудыг бодвол илүү цар хэмжээтэй байв. Түүнчлэн

Хаттам (Hattam) Америк дахь ажилчны хөдөлгөөний сул хөгжлийг тайлбарлахыг хүссэн бөгөөд Америкийн намуудын бүтэц болон сонгуулийн институцүүд нь үйлдвэрчний эвлэлийг зохион байгуулагчдын хувьд улс төрийн стратеги хийх урам зориг, хөшүүрэг болдоггүй гэдгийг олж тогтоосон байна. Улмаар энэ нь Америкийн улс төрийн соёлынх нь өвөрмөц байдалд бус, харин бусдаас ялгарах улс төрийн институцүүдийнх хэсэгчлэгдсэн (fragmented) байдлын бүтээгдэхүүн гэдгийг заажээ. (Steinmo, 2008)

Эх газрын буюу аж үйлдвэрийн ололтын загвар

Улс төрийн эдийн засаг нь консерватизм, корпоратизмд суурилан бүрэлдсэн байх ба патерналист үзлийг ч агуулдаг. Нийгмийн хамгааллын үнэт зүйл нь хүн амын нийгмийн баталгаат байдал, дэг ёс, тогтвортой байдал учраас институцийн гол зорилго нь хувь хүн, бүлгүүдийн социаль статусын ялгаа, шатлалыг хадгалах, хүй элгэн, нутгийн нийтлэгийг бэхжүүлэх зэрэгт чиглэдэг. (Ulrich, 2005, p. 52) Энэ загварт нийгмийн хамгааллын институцийн амин чухал үүрэг бол эдийн засгийн системийг дэмжигч түүний төлөө бий болж буй зүйл гэж үздэг. Энэ хэв маягт оюун ухаан, ажлын гүйцэтгэл, бүтээмжит байдал зэрэг нь хүмүүсийн сайн сайхны буюу хамгааллын хэрэгцээг хангах үндэс болдог. Үүнийг бас өөрөөр зарц эмэгтэйн загвар (Handmaiden Model)²⁵⁰ гэж нэрлэх нь ч бий. (Richard Tittmus, 1974, p. 29) Хэв маягийг илэрхийлэх түүчээ орнууд нь Герман, Франц, Австри зэрэг юм.

Нийгмийн хамгааллын бодлогын стратеги нь ажил эрхлэлтэд суурилсан нийгмийн баталгаат байдлыг бий болгох явдал юм. Нийгмийн хамгааллын бодлогын түлхүүр арга хэмжээ нь даатгал бөгөөд үйлчилгээний тогтолцоо нь ажлын гүйцэтгэлээр тооцох, шимтгэлийн хувь төлөлтөөр тодорхойлох, оролцогч талуудын социаль түншлэлийг (төр, үйлдвэрчний эвлэл, ажил олгогч) бий болгох зэрэг онцлогуудыг агуулах бөгөөд хүн амын бүлгийг хамрах хүрээ (coverage rate), нөхөн олговрын хэмжээ (replacement rate) зэргээрээ бусад хэв загвараасаа өндөр байж чаддаг. Тухайлбал Герман улсын ажилгүйчүүдэд олгодог тэтгэмж дээрх үзүүлэлтүүдээр хамгийн өндөрт тооцогдох ба өгөөмөр байдлын индексээр (generosity index) тэргүүлж ирсэн юм. Энэхүү хэв маягт нийгмийн халамж, тусламжийн арга хэмжээнүүд нийгмийн хамгааллын хоёрдогч чиглэл болдог.

Нийгмийн хамгааллын бүхий л үйлчилгээнд нь сүбсидиар зарчим хүчтэй хэрэгждэг. Мөнгөн шилжүүлэг, халамжийн үйлчилгээний аль ч, хүй элгэн, орон нутаг өөрсдийн асуудлыг шийдвэрлэх ёстой, харин эдгээр нь шийдвэрлэж чадахгүй байгаа тохиолдолд дараагийн түвшин (муж, цаашилбал холбооны засгийн газар) оролцох болно. Нийгмийн баялгийг дахин хуваарилах түвшин өндөр байдаг ч умардын загвараас ялгаатай нь нэгдүгээрт, дахин хуваарилалтыг болон универсал үйлчилгээг төв засгийн газраас бус муж, хотоос хэрэгжүүлнэ, хоёрдугаарт, үйлчилгээнээс илүүтэй мөнгөн шилжүүлгийн хэлбэр давамгайл явагддаг. (Kaufmann F.-X. , 2000) Ингэхдээ хүй элгэн, орон нутгийн түвшинд түлхүү хэрэгжих учир шалтгаан нь муж улс, хотын түвшинд нийгмийн хамгааллын мөнгөн шилжүүлгүүд үлэмж байр суурь эзэлдгийг хэлж байна. Холбооны улсын засгын газраас хүүхдийн мөнгө гэх мэт зарим цөөн төрлийн мөнгөн шилжүүлгийг л хариуцдаг байна. Энэ нь нэг талаас дундад зууны үеийн феодалын газар эзэмшлийн нэгдлүүд, шашны сүмийн засаг захиргаа, түүний харъяа нутгийн уламжлалтай ихээхэн холбогдоно. Католик шашны гол суртал мэдээ нь хүй элгэнүүд өөрсдийн ядуус болон бусад асуудлыг шийдвэрлэхэд онцгой байр суурьтай байх ёстой гэдэг. Мөн нийгмийн халамж, тусламжийн үйлчилгээг гүйцэтгэхэд үндэсний хэмжээнд төлөвшсөн ашгийн бус байгууллагууд гол үүрэг гүйцэтгэдэг. Тэдгээр нь тусламж, дэмжлэг, нийгмийн ажилтан, сэтгэлзүйч, сурган хүмүүжүүлэгч гэх мэт мэргэжлийн үйлчилгээ шаардлагатай байгаа бүлгүүдэд үйлчилгээг хүргэх ба ингэхдээ төрөөс санхүүгийн үлэмж дэмжлэг авдаг. Эдгээр байгууллагыг нийгмийн үйлчилгээг хүргэгч хэмээн нэрийдэх ба удаан жилийн тогтсон систем болжээ. Жишээлбэл ХБНГУ-д үндэстэн даяар тусламж үйлчилгээг хүргэдэг таван байгууллага байх ба өндөр түвшинд институцчилэгджээ. Католик шашны уламжлалт үнэт зүйлс, түүний сүм хийдийн институцчилэл нь эх газрын тэр дундаа баруун европын эл загвар бүхий орнуудад нийгмийн бодлого, хамгааллын

250 Энэ нь халамж бол аж үйлдвэрийн хөгжлийн зайлшгүй нэмэлт хүчин зүйл гэсэн утгатай.

салбартаа ихэд нөлөөлсөн байна. Дээр дурдсанчлан Америкт зах зээл, гэр бүл, сүм хийдийн хүрээнд хэрэгцээгээ хангаж чадахгүй тохиолдолд халамжийн үйлчилгээ хүртээмжтэй болдог бол, Германд гэр бүл нь чадахгүй бол дүүрэг, хотын түвшинд халамж хүргэх ба, харин үүнээс цааш асуудалд муж, цаашилбал холбооны нийгмийн хамгаалал хүртээмжтэй гэсэн санаа юм.

Нийгмийн хамгааллын системд үйлдвэрчний эвлэлийн гүйцэтгэх үүрэг ихээхэн чухал байж ирсэн нь түүхэн уламжлалтай билээ. Ажилчны хөдөлгөөний өлгий орнууд энэ хэв маягт багтдагтай холбоотой бөгөөд олон улсын социалист интернациональ хөдөлгөөний уламжлал улс төрийн бодлого хийгээд институцүүдэд нь гүнзгий нөлөө үзүүлсэн юм. Нэг талаас католик шашны уламжлал, нөгөө талаас иргэний амьдрал дахь уламжлалыг эрхэмлэх консерватив үзлийг илүүтэй өвлөж ирсэн нь гэр бүлийн болон хөдөлмөр эрхлэлтийн бодлогод нь гүн гүнзгий нөлөөлсөөр ирсэн билээ. Гэр бүлийн бодлогын мөн чанар нь нэг талаас төрөлтийг дэмжих, нөгөө талаас аж үйлдвэрийн хувьсгалаас хойш төлөвшсөн *гэр бүлийн уламжлалт цөм загварыг хадгалахад* үндсэндээ чиглэж байдаг. Герман, Франц, Австрийн гэр бүлийн бодлого нь саяхныг хүртэл эрэгтэйчүүд өрхөө тэжээгч (bread winner) харин эмэгтэйчүүд (house keeper) ар гэрээ авч явагч гэсэн уламжлалт цөм загварыг хадгалах зорилгыг илүү тээж ирсэн ба эл бодлого консерватив нийтийн сайн сайхны төрийн тулгуур багана билээ. Тиймээс холбооны болон мужийн засгийн газраас эмэгтэйчүүд, хүүхдэд чиглэсэн мөнгөн тэтгэмжийн өгөөмөр системийг бий болгох ба энэ нь эмэгтэйчүүд гэртээ хүүхдээ хүмүүжүүлэх, мөн төрөлтийг дэмжих давхар функцийг агуулдаг байна. Харин сүүлийн үед уг бодлогын илэрхий үр дүн болсон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн ялгарал буурч, модернжилтийн үйл явц эмэгтэйчүүд хөдөлмөрийн зах зээлд тэгш эрхтэй оролцоход түлхэж байгааг судлаачид тэмдэглэж байна.

Өмнөдийн буюу латины загвар

Дундад зууны хожуу хийгээд сэргэн мандлын үеийн европын хүчирхэг орнууд болох Итали, Испани, Португал зэрэг нь аж үйлдвэрийн хувьсгалын эрин үед улс төр, эдийн засгийн ноёрхлоо эх газрын европын орнуудад алдсан билээ. Газар дундын тэнгисийн гэгдэх Итали, Испани, Португал болон Грек гэсэн орнуудын хувьд Андерсений хэв маягт системтэй хамрагдаж чадаагүй түүний гадна үлдсэн гэж үздэг. Тэрээр Италийг эх газрын европын корпоратист загварт зарим талаар хамруулсан тал бий. Судлаачдын дунд дээрх орнуудын нийтийн сайн сайхны төрийг бие даасан загвар мөн үү эсвэл аль нэг хэв маягт хамаарах уу гэх маргаан хэлэлцүүлэг бий болдог. Харьцуулсан нийгмийн хамгааллын судлаач Шмидийн хувьд “Пост авторитет” гэсэн хэв маягийг дэвшүүлсэн бол Катроугалос (Katrugalos) зэрэг судлаачдын зүгээс “Өмнөдийн буюу “Латин Римийн загвар” гэсэн нэршил бий болгож, бие даасан нийгмийн хамгааллын хөгжлийн загварыг бүрдүүлсэн гэж үздэг.

Нөгөө талаас дээрх орнууд нь нийгмийн хамгааллын бие даасан хөгжлийн загварыг бий илтгэхгүй агаад харин эх газрын европын хэв маягт багтах дэд бүлэг (subcategory) гэж үзэх нь бий. Учир нь бусад орнуудыг бодвол нийтийн сайн сайхны төр нь харьцангуй сул хөгжсөн, эрийн цээнд хүрээгүй гэгцгээдэг. Гэвч энэ бүлэг орнуудын хувьд нийгмийн болон төрийн институцийн хувьд бусдаас ялгарах зарим нийтлэг шинж чанартай. Юуны өмнө социаль харилцаанд католик шашны ул мөр (catholic imprint) шингэсэн байдлыг (Грекийг эс тооцвол) дурдах хэрэгтэй. Мөн гэр бүлийн институцийн эзлэх жин, гүйцэтгэх үүрэг нэн өндөр бөгөөд гэр бүлсэг харилцааны (strong familialism) уламжлал хүчтэй юм. Түүнчлэн төрийн бүрэн эрхт хүчний хэв маяг (хаант засаг) түүний нийгэмд үүлэх нөлөө, уламжлал үлэмж их билээ. Нийгмийн хамгааллын системд эдгээр шинж чанарууд нь ихээхэн нэвчсэний дээр үзэл санааны, институцийн, эдийн засгийн, социаль болон соёлын гээд олон талын нөлөө үзүүлж ирсэн нь дамжиггүй. Лайбфрийд (Leibfried) болон Лессенич (Lessenich) зэрэг судлаачид эдгээр орнуудыг посавторитар хэв маяг хэмээн нэрийдэж Испанийг гол жишээ болгон дараах онцлог шинжүүдийг тоочжээ. (Schmid, 1996) Нийгмийн бодлогын дэглэм нь рудимент шинж чанарыг тээж ирсэн ба төрөөс нийгмийн салбарыг зохицуулах гол үзэл санаа нь модернжилт дээр төвлөрч байгаа, хөдөлмөр эрхлэлтийн талаарх зохицуулалтаа цуцалж буй, хөдөлмөр эрхлэлтийн салбар нь тогтвортой байдал хийгээд найдваргүй байдлын харьцаагаар тодорхойлогдон буй, хөдөлмөрийн зах зээл дэх тэгш бус байдал нь зарим ажлын байрны найдваргүй байдлаар илрэх

болсон зэргийг дурджээ. (Schmid, 1996, p. 228) Ингэхдээ сайхь судлаачид саяхны Испаний нийтийн сайн сайхны төрийн байр байдалд тулгуурлан дүгнэсэн байна. Саяхнаас газар дундын тэнгисийн орнууд дахь тухайлбал Грекээс эхлэн Испанийг дайрсан нийтийн сайн сайхны төрийн хямрал европын холбооны төдийгүй дэлхийн түвшинд анхаарал татсан асуудал болж байгаа бөгөөд өнөө хир нь хямралт шинж үргэлжилсээр байна.

Бүтээмжит нийтийн сайн сайхны төрийн загвар

Азийн бар хэмээгддэг орнуудын нийтийн сайн сайхны төрийн загварын тухай хэлэлцүүлэг ихээхэн өрнөх болсон юм. Хонгконг, Сингапур, Тайван зэрэг орнуудын нийгмийн хамгааллын тогтолцоог судласаны үндсэн дээр бүтээмжит нийтийн сайн сайхны төр (productive welfare state) гэсэн ойлголтыг дэвшүүлсэн билээ. Дээр дурдсанчлан Япон, Өмнөд Солонгосыг либерал халамжийн буюу ризидуал загварт оруулахаас гадна, зарим тохиолдолд ерөөс бүтээмжит нийтийн сайн сайхны төр гэгч нь азийн хөгжилтэй орнуудыг бүхэлд нь хамарсан хэв маяг ч гэж үзэх нь бий. Өөрөөр хэлбэл азиас цаг хугацааны хувьд түүчээлэн хөгжсөн дээрх хоёр орны хувьд ч бүтээмжит нийтийн сайн сайхны төрийн шинж чанаруудыг тогтолцооны болон хамгааллын институцийн хувьд хадгалж байдаг гэжээ. 1990 оноос зүүн азийн нийгмийн бодлогын туршлага евро-америк загвараас зарчмын ялгаатай гэсэн байр суурь академик хүрээнд бий болж эхэлсэн байна. Гэвч зүүн азийн ялгааг баримтлагчдын дунд нэгдсэн зөвшил байхгүй байсаар ирсэн билээ. Судлаачдын дунд бүс нутгийн кластерийг үндэслэн “Эдийн засагч нийтийн сайн сайхны төр”, “Конфуцийн нийтийн сайн сайхны төр”, “Япон төвт зүүн азийн нийтийн сайн сайхны төр”, “Зүүн азийн хамгааллын загвар” гэх мэтээр тодорхойлох хандлагууд бий болсон. Эдгээр эрдэмтдийн дунд нийгмийн хамгааллын бүс нутгийн кластертаа хэрхэн хамруулж байгаагаараа ялгарах ба зарим нь япон, өмнөд солонгос, тайван зэрэг орнуудыг л хамруулах жишээтэй. Судлаачид бүтээмжит нийтийн сайн сайхны төрийн хоёр гол шинж чанарыг нэг талаас өсөлтөд баримжаалсан төр, нөгөө талаас нийгмийн бодлогыг оролцуулаад төрийн бодлогын бүхий л салбар нь эдийн засгийн/аж үйлдвэрийн зорилгод чиглэсэн түүнээс хамааралтай байгааг онцолсон байдаг. Бодлого боловсруулагчид нь эдийн засгийн өсөлтийг дэмжих хүчний хайгуульд гарах ба нийгмийн бодлогыг дэмжих арга хэрэгсэл гэж харна. Тиймээс нийгмийн бодлого нь өргөн хэмжээнд түгээмэл (universalistic) үйлчилгээнүүдийг бий болгон басхүү хувь хүнийг дэмжихэд чиглэсэн тусгай (particularistic) үйлчилгээнүүдийг ч бүтээх аж. Бүтээмжит нийтийн сайн сайхны төрийн үед *дэмжигч (facilitative)*, *хөгжлийн түгээмэл хандлагат (developmental universalist)*, *хөгжлийн тусгай хандлагат (developmental particularist)* гэсэн гурван төрлийн нийгмийн хамгааллын үйлчилгээ зэрэгцэн оршдог ба эхнийх нь Андерсены хэв маягаар либерал баримжаалал бүхий өрсөлдөөнийг тэтгэх, түүнд байр тавьж өгөх, араас нь дэмжих бодлого, харин удаах нь үйлдвэрлэлд холбогдох зарим төрлийн социаль эрхийг баталгаажуулах замаар хүн амын бүтээмжит байдлыг, түүнчлэн хөдөлмөрийн язгууртнуудыг дэмжих бодлого, сүүлийнх нь хувь хүнд сэтгэл ханамжтай үйлчилгээг бүтээж нийгэм дэх бүтээмжийн элементийг дэмжих бодлого болно. Ийнхүү бүтээмжит халамжит капитализмд хамаарах азийн хөгжилтэй улс орнууд гурван дэд хэв маягт хамаарах бөгөөд тухайлбал Япон, Өмнөд Солонгос, Тайван хөгжлийн түгээмэл хандлага, харин Сингапур хөгжлийн тусгай хандлага бүхий, Хонгконг дэмжигч (хөгжлийн түгээмлийн элементүүдийг агуулдаг) нийгмийн хамгааллын бодлогыг баримжаалдаг аж. (Holliday, 2000, pp. 709- 713) Ерөнхийдөө бүтээмжит нийтийн сайн сайхны төр гээч нь хөгжлийн төрийн (developmental state) үе дэх нийгмийн хамгааллын институц ямар байх ёстой, яаж хөгжих ёстойг илтгэн харуулж буй хэв загвар бололтой. Учир нь дээрх орнуудыг капитализмын хөгжлийн бас нэгэн өвөрмөц замнал гээд хөгжлийн төрийн жишээ болгон авч үздэг. Энэ үед төрийн нийгмийн хамгаалал нь бүтээмжит байдлыг дэмжих, тиймээс хувийн хэвшлийн бүтээмжит байдлыг өсгөн нэмэгдүүлэх зорилгод нийгмийн хамгааллыг уях, зах зээлийг чухалчлах, төр нь зах зээл болон гэр бүлд суурилах үзэл санааг цөмөө болгоно. Хөгжлийн төр хэмээх ойлголтыг анх Чалмерс Жонсон зүүн азийн хөгжингүй капиталист орнуудын замналыг харуулах зорилгоор дэвшүүлсэн бөгөөд зах зээл капитализмын хөгжлийн гол хүчин зүйл гэсэн сонгодог томъёоллоор бус, харин ухаалаг төрийн оролцоо, үйлдэл чухал үүрэг гүйцэтгэсэн болохыг заажээ. Өсөлт, бүтээмжит байдал өрсөлдөөнөөр тодорхойлогддог

эдийн засгийн хөгжил нь төрийн нэн тэргүүний, ухаалаг үйлдлийг бүтээх ба хувийн өмч, зах зээлд үнэнч байх зарчим бий болно. Төрийн интервенц нь чухамдаа энэхүү зарчмын хүрээнд бүрэлдэх учиртай бөгөөд нийгмийн зөрчлийг барууны капиталист орнуудын адил заавал нийгмийн хамгааллын өргөн хөтөлбөрүүдээр зохицуулах шаардлагагүй, түүнээс өөр аргаар зайлсхийж чадаж аж. Гэвч эдгээр орнуудад эдийн засгийн авсаархан хэмжээтэй, шилмэл бюрократ тогтоц зах зээлийг удирдах бюрократ тогтолцоон дахь туршилтын агентлагууд нь бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд түлхүүр үүрэг гүйцэтгэнэ. Шилмэл бюрократууд болон бизнесийнхний дунд зөвлөлдөх хийгээд хамтран ажиллахад чиглэсэн хаалттай институтчилэгдсэн холбоо бий болно. Стратегийн аж үйлдвэрийн бодлого бол хөгжлийн төрийн загварын цөм нь болдог гэжээ. (Oenis, 1991, p. 111)

Корпоратив капитализмын ийм онцлог бүхий загварын үед нийгмийн хамгааллын институцид төрийн тэтгэмжүүдээс гадна компаниудын үүрэг оролцоо асар өндөр бөгөөд ажилчин хүн нэг насныхаа нийгмийн баталгааг хангахын тулд өөрийн дээд зэргийн бүтээмжит хөдөлмөрөө эргээд тэдгээрт зориулах ёстой. Тэгэхээр төрийн нийгмийн даатгал, түүнчлэн профессор Титмуссын тодорхойлсон эрхэлж буй ажилтай нь холбоотойгоор компаниудаас олгогдох ажлын тэтгэмж (occupational welfare) ихээхэн чухал юм.

Социализмын дараах нийтийн сайн сайхны төрийн загвар

Социализмын дараах орнуудын хөгжлийн замнал ихээхэн төвөгтэй явагдаж ирсэн билээ. Институцийн улс төрийн судлаачид эл орнууд дахь хөгжлийн үйл явцыг ихээхэн ялгаатай үр дүнг бий болгож байгааг тэмдэглэдэг. Эдгээр орнуудын нийгмийн хамгааллын систем нь бие даасан загвар гэдэг нь академик хүрээнд нийтээр хүлээн хүлээн зөвшөөрсөн итгэл үнэмшил биш ч гэсэн зарим судлаачид хөгжлийн нэгэн өвөрмөц загвар гэж тэмдэглэдэг. Социалист нийгмийн хамгааллын тогтолцооны үеийн өв уламжлалын дээр зах зээлийн системд нийцүүлэн хийгдсэн шинэчлэлийн асуудал яригдах ба ерөнхийдөө шилжилтийн гэх үйл явц нь эдгээр орнуудын хөгжлийн чиг шугмыг судлахад төвөгтэй болгожээ. Өөрөөр хэлбэл нийгмийн хамгааллын системд шилжилтийн үйл явцын үзүүлсэн нөлөөллийн ялгаатай байдлыг авч үзэхгүйгээр шууд нэгэн загварт оруулах нь боломжгүй гэдгийг судлаачид тэмдэглэдэг. Тухайлбал нийгмийн даатгалын зарчим гэхэд социалист орнуудад өрнөдийн капиталист орнуудтай харьцуулахад суурь зарчмын хувьд ижил боловч, өөрийн онцлогыг бий болгожээ. ОУХБ-ын нийгмийн даатгалын загвар нь эв санааны нэгдлийн зарчимд суурилдаг. Зөвлөлтийн систем энэхүү суурь зарчмыг дээрх байгууллагаас авсан бөгөөд өөрийн улс төрийн эдийн засгийн онцлогт нийцүүлэн хувиргажээ. Харин зөвлөлт систем унасаны дараа дээрх системийн орнууд капиталист орнуудад хэрэгжиж буй нэгэн адил шинэчилсэн байна. Социалист тогтолцооны үед ажилтны нийгмийн даатгалын шимтгэл гэж үгүй, тэтгэвэр тэтгэмж төвлөрсөн төсвөөс төлөгддөг байсан бол, зах зээлийн үед ажилтан ажил олгогч нарын шимтгэлд сууриалдаг болно. Харин нийгмийн халамжийн хувьд олон хүүхэдтэй гэр бүлд, эхчүүдэд олгож байсан тэтгэмжүүдийг зарим орон өвлөн авч хэрэгжүүлсэн нь бий. Мөн социалист тогтолцооны үед эмзэг бүлгийнхэнд олгож байсан тэтгэмжүүдийг өвлөн авсан байдаг. Социализмын дараах нийтийн сайн сайхны төрийн хөгжлийн хувьд зарим нийтлэг онцлогыг дурдаж болох байна. Нэгдүгээрт, социализмын нийгмийн бодлогын өвийг нэлээд хэмжээнд уламжлан авсан, хоёрдугаарт, олон улсын санхүүгийн байгууллагуудын нөлөөнд түүний шууд удирдамжийн хүрээнд либерал капитализмын зарчмаар бүрэлдсэн зэрэг юм.

Дүгнэхүй

Социологийн сонгодог төлөөлөгч Веберийн тодорхойлон дэвшүүсэн идеаль хэв шинж бол социаль үзэгдлийн талаарх судлаачдын цаасан дээр байгууламж санаалаг байгууламж боловч, эргээд нийгмийн харилцааг танин мэдэхэд асар чухал үүрэгтэй юм. Нийтийн сайн сайхны төрийн хэв маягчлал улс орнуудын төрийн зүгээс зохион байгуулж байгаа нийгмийн хамгааллын системийн талаарх идеаль хэв шинж мөн. Энэ нь *бидэнд нийтийн сайн сайхны төрийн ялгаатай дэглэмүүдийг, нийгмийн хамгааллын системүүдийн харилцан адилгүй шинж чанаруудыг харьцуулан эргэцүүлэх*

боломжийг олгодог. Нийтийн сайн сайхны төрийн идеаль хэв маягууд гэхийн учир нь Андерсений болон бусадаль хэв маягууд нь цэврээрээ бодит байдал дээр оршин байхгүй бөгөөд харин янз бүрийн хэв маягууд холимог байдлаар оршин байдаг. Улс орнуудын нийгмийн хамгааллын системийг нийтийн сайн сайхны төрийн ямар хэв маягт хэрхэн хамруулах вэ? гэсэн асуултад хариулахын тулд тухайн улс оронд нийтийн сайн сайхны төрийн аль хэв маяг илүү давамгайлах байдалтай оршин буйг тодорхойлох хэрэгтэй болно.

Эшлэсэн ном зохиолууд

1. Allan Cochrane, J. C. (2001). *Comparing Welfare State, Second Edition. Vol 5*. New York: Sage Publication.
2. Arcanjo, M. (2006). *Ideal (and Real) Types of Welfare State*. Lisbon: CISEP – Research Centre on Portuguese Economy.
3. Esping-Andersen, G. (1990). *The Three Worlds of Welfare Capitalism*. Cambridge: Polity Press.
4. Hilson, M. (2008). *The Nordic model : Scandinavia since 1945*. London: Reaktion Books.
5. Holliday, I. (2000). Productivist Welfare Capitalism: Social Policy in East Asia. *Political Studies, Vol. 48* .
6. Kaufmann, F. X. (2003). *Varianten des Wohlfahrtsstaates, Der deutsche Sozialstaat in internationalen Vergleich*. Bielefeld: Verlag.
7. Kaufmann, F.-X. (2000). Towards a Theory of the Welfare State. *European Review* .
8. Naegel, G. B. (2008). *Sozialpolitik und Soziale Lage in Deutschland, Band 1: Grundlagen, Arbeit, Einkommen und Finanzierung*. Heidelberg: VS Verlag für Sozialwissenschaften.
9. Oenis, Z. (1991). The Logic of the Developmental State. *Comparative politics, Vol.24* .
10. Pierson, S. T. (2002). Historical Institutionalism in Contemporary Political Science. *Political science: The state of the discipline 3* .
11. Richard Tittmus, A.-S. a. (1974). *Social Policy: An Introduction*. New York: Pantheon Books .
12. Schmid, J. (1996). *Wohlfahrtsstaaten im Vergleich, Soziale Sicherungssysteme in Europa: Organization, Finanzierung, Leistungen und Probleme*. Bochum: Leske-Budrich Opladen.
13. Schmidt, M. G. (1988). *Sozialpolitik. Historische Entwicklung und Internationaler Vergleich* . Frankfurt: Opladen.
14. Steinmo, S. (2008). Historical Institutionalism. In *Approaches and Methodologies in the Social Sciences: A Plurali*. Cambridge: Cambridge University Press.
15. Ulrich, G. G. (2005). *Soziologie des Wohlfahrtsstaates. Eine Einfuehrung*. Frankfurt in Main: Campus Verlag.
16. Walters, F. N. (2006). Privatization, Income Distribution, and Poverty: The Mongolian Experience. *World Development Vol. 34, No. 9* .